

# ЦЭРГИЙН БА НИЙГМИЙГ АЮУЛААС ХАМГААЛАХ ХЭРГИЙГ ЭРХЛЭХ ЯАМ

## 1955-1959

## MINISTRY OF MILITARY AND SOCIAL SECURITY AFFAIRS



Дэслэгч генерал
Цэдэнгийн Жанчив
1955-1956

Lieutenant General
Janchiv Tseden



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

Зарлиг

1955 он 7 дугаар сарын 9 өдөр, дугаар 59
Улаанбаатар хот

Улсыг Батлан Хамгаалах Яам ба
Дотоод Явдлын Яамдыг нэг
Яам болгон нэгтгэх тухай.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Улсыг Батлан Хамгаалах Яам ба Дотоод Явдлын Яамыг нэгтгэж, тэдгээрийн оронд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Цэргийн ба Нийгмийг Аюулаас Хамгаалах Хэргийг Эрхлэх Яамыг байгуулсугай.

2. Монгол Ардын Хувьсгалт Цэргийг цаашдаа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ардын цэрэг гэж нэрлэж байсугай.

3. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Цэргийн ба Нийгмийг Аюулаас Хамгаалах Хэргийг Эрхлэх Яамны сайдаар дэслэгч генерал н. Цэдэнгийн ЖАНЧИВЫГ томилсугай.

4. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Цэргийн жанжингаар дэслэгч генерал н. Санжийн БАТАА-г томилсугай.

Б. Н. М. А. Улсын Их Хурлын
Тэргүүлэгчдийн дарга (САМБУУ)
Б. Н. М. А. Улсын Их Хурлын
Тэргүүлэгчдийн орлогч дарга (ЦЭДЭВ)
Б. Н. М. А. Улсын Их Хурлын
Тэргүүлэгчдийн нарийн
бичгийн дарга (ШАРАВ)

Тэргүүлэгчид
(ДАМБА)
(ЯНЖМАА)
~~(НОГООН)~~
(ТӨМӨР-ОЧИР)

ТБА, Х-11, Д-2, ХН-165, Х-107



172.
142

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ
НАМЫН ТӨВ ХОРООНЫ УЛС ТӨРИЙН
ТОВЧООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

1956 оны 4 дугаар сарын 26-ны өдөр

№ 115.

Улаанбаатар хот

ЦЭРЭГ БА Н А Х Х Э ЯАМНЫ
САЙДЫГ БАТЛАХ ТУХАЙ

М А Х Намын Төв Хорооны Улс
Төрийн Товчооноос ТОГТООХ НЬ:

1. Цэрэг ба Н А Х Х Э Яамны сайдаар нөхөр Батын Дор-жийг батлагсугай.

2. Өөр ажилд баталсан учир нөхөр Доржийг Совмонголметалл-нийгэмлэгийн ерөнхий захиргааны орлогч даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. Цэрэг ба Н А Х Х Э Яам ба Улсыг Аюулаас Сахих Хамгаалах Газрын ажилд тодорхой өөрчлөлт гарган сайжруулж чадаагүй учир нөхөр Ц.Жанчив,Д.Батаа нарыг Цэрэг ба Н А Х Х Э Яамны сайд,Улсыг Аюулаас Сахих Хамгаалах Газрын даргын үүрэгт ажлуудаас тус тус чөлөөлсүгэй.

УЛС ТӨРИЙН ТОВЧООНЫ ГИШҮҮД
(Ю. ЦЭДЭНБАЛ)
(Д. ДАМБА)
(Ж. САМБУУ)
(Б. ШИРЭНДЭВ)
(Н. ЛХАМСҮРЭН)
(Б. ДАМДИН)
(Д. БАЛЖИННЯМ)

ОРЛОГЧ ГИШҮҮД
(Ц. ДҮГЭРСҮРЭН)
(Б. ЖАМБАЛДОРЖ)

УТНОНББА, Х-4, Д-23, ХН-11, Х-142



Дэслэгч генерал
Батын Дорж
1956-1959

Lieutenant General
Dorj Bat

ЦЭРЭГ БА НИЙГЭМИЙГ АЮУЛААС ХАМГААЛАХ ХЭРГИЙГ
ЭРХЛЭХ ЯАМНЫ САЙДЫН ОРЛОГЧ Б-Г-Д АРДЫН ЦЭРГИЙН
КОМАНДЛАГЧИЙН ТУШААЛ.

№ 045

1956 оны 5-р сарын 14 Улаанбаатар хот.

---

Утга нь: Ардын цэргийн анги салбар, албан байгууллагуудыг тайван цагийн шинэ орон тооны зохион байгууллалтад шилжүүлэн оруулах ба зарим ангиудыг татан буулгах тухай.

---

Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн шийдвэрийг үндэслэж Ардын цэргийн анги салбар, албан байгууллагуудыг тайван цагийн зохион байгуулалтанд зохицуулан өөрчлөн зохион байгуулж шинэ орон тоонд шилжүүлэн оруулахын тулд ТУШААХ НЬ:

ргийн ерөнхий

Нэг. Өөрчлөн зохион байгуулах нь:

1. Маршал Чойбалсангийн нэрэмжит 6 дугаар мото-механикжуулсан хороог маршал Чойбалсангийн нэрэмжит нэгдүгээр буудлагын батальон.
2. Барилгын нэгдүгээр батальоныг буудлагын 2 дугаар батальон.
3. Авто хангах ротыг авто хангах баз.

ивзион.

4. Түлш бэлтгэх ротыг түлш бэлтгэх групп болгон тус тус өөрчлөн зохион байгуулсугай.

Хоёр. Шинээр зохион байгуулах нь:

1. Их буугийн тусгай дивзион.
2. Танкийн тусгай рот.
3. Холбооны тусгай рот.
4. Сапёрын тусгай рот.
5. Хүндэт харуулын тусгай рот.
6. Биеийн тамир-спортын тусгай ротуудыг 5-р сарын 15-наас 25-ны дотор тус тус шинээр зохион байгуулж дуусгахыг Ардын цэргийн штабын дарга

а анги салбаруудыг
6-ны дотор бат-
уч генерал Балданд
г нөхөн хангаж
н бүх тайлан тоо-

цооны ба бусад зохион байгуулалтын ажиллагаануудыг 5-р сарын 15-аас эхлэн 6-р сарын 1-ний дотор гүйцэтгэхийг Ардын цэргийн штаб ба арын албаныг удирдах хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

ЦЭРЭГ БА НИЙГЭМИЙГ АЮУЛААС ХАМГААЛАХ
ХЭРГИЙГ ЭРХЛЭХ ЯАМНЫ САЙДЫН ОРЛОГЧ Б-Г-Д
АРДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ
/ ЛХАГВАСҮРЭН /

БХТА, С-1, Д-2, ХН-274, Х-79



Цэрэг ба Нийгмийг Аюулаас Хамгаалах Хэрэг Эрхлэх яамны сайд, Ардын цэргийн командлагч дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн дайчдын хамт.
Lieutenant General J.Lkhagvasuren, Minister of Military and Social Security Affairs, Commander-in-Chief, with soldiers.



Дайчид биеийн тамирын хичээлд Soldiers at physical training

# ЦЭРГИЙН БА НИЙГМИЙГ АЮУЛААС ХАМГААЛАХ ЯАМ, АРДЫН ЦЭРГИЙН ЖАНЖИН ШТАБЫН УДИРДЛАГУУД

## LEADERSHIP OF THE MINISTRY OF MILITARY AND SOCIAL SECURITY AFFAIRS AND GENERAL STAFF OF PEOPLE'S MILITARY FORCE



Зүүн гар талаас хошууч генерал Б.Цог, дэслэгч генерал Б.Дорж, хошууч генерал Д.Дамдинхүү нар

From left side, Major General B.Tsog, Lieutenant General B.Dorj, and Major General D.Damdinkhuu



Ардын цэргийн Ерөнхий штабын дарга хошууч генерал Д.Дамдинхүү

Major General D.Damdinkhuu, Chief of the General Staff of the People's Military Forces



Цэрэг ба НАХХЭЯ-ны сайд дэслэгч генерал Б.Дорж хээрийн сургуулийн явцтай танилцаж буй нь.

Lieutenant General B.Dorj, Minister of Military and Social Security Affairs, at the field exercise.



Хурандаа Н.Дугаржав, хурандаа Н.Паль, ахмад Шэрчин-Ойдов, хошууч Ж.Наадгай, хошууч Ц.Содов, ахмад Сүрэн, ахмад С.Гангааням болон бусад офицерууд.

Colonel N.Dugarjav, Colonel N.Pali, Captain Shirchin-Oidov, Major J.Naadgai, Major S.Oidov, Captain Suren and Captain S.Gangaanyam, and other officers.

# ӨӨРЧИЛӨН ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН МАРШАЛ Х.ЧОЙБАЛСАНГИЙН НЭРЭМЖИТ НЭГДҮГЭЭР БУУДЛАГЫН БАТАЛЬОН

## REORGANIZED FIRST RIFLE BATTALION, NAMED AFTER MARSHAL KH.CHOIBALSANG



БНМАУ-ын Ардын цэргийн жанжны 1956 оны 46 дугаар тушаалаар томилогдсон 1 дүгээр буудлагын батальоны дарга, хурандаа Наваны Баасан

Colonel Baasan Navaan, appointed by order #46 of the Commander-in-Chief of the PRM on 1956, Commander of the 1st infantry battalion











## ШИНЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ИХ БУУГИЙН ТУСГАЙ ДИВИЗИОН
REORGANIZED ARTILLERY BATTALION



БНМАУ-ын Ардын Цэргийн жанжны 1956 оны 46 дугаар тушаалаар томилогдсон их буугийн тусгай дивизионы дарга, хошууч Цэдэвийн Содов

Major Sodov Tsedev, appointed by order #46 of the Commander-in-Chief of the PRM on 1959, Commander of the Artillery Battalion

## ШИНЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТАНКИЙН ТУСГАЙ РОТ

REORGANIZED TANK COMPANY



БНМАУ-ын Ардын цэргийн жанжны 1956 оны 50 дугаар тушаалаар томилогдсон танкийн тусгай ротын дарга, ахмад Лүдэвийн Сэрээнэн

Capitan Sereenen Ludev, appointed by order #50 of the Commander-in-Chief of the PRM on 1956, Commander of the Tank Company











## ШИНЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ХОЛБООНЫ ТУСГАЙ РОТ
### REORGANIZED COMMUNICATIONS COMPANY



БНМАУ-ын Ардын цэргийн жанжны 1956 оны 49 дүгээр тушаалаар томилогдсон холбооны тусгай ротын дарга, ахлах дэслэгч Сайжрахын Гангааням

Lieutenant Gangaanyam Saijrah, appointed by order #49 of the Commander-in-Chief of the PRM on 1956, Commander of the Communications Company

ШИНЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН
САПЁРЫН ТУСГАЙ РОТ
REORGANIZED SAPPER COMPANY



БНМАУ-ын Ардын цэргийн жанжны 1956 оны 51 дүгээр тушаалаар томилогдсон сапёрын тусгай ротын дарга, хошууч Жамцын Чимид

Major Chimed Jamts, appointed by order #51 of the Commander-in-Chief of the PRM on 1956, Commander of the Sapper Company











## ШИНЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ХҮНДЭТ ХАРУУЛЫН ТУСГАЙ РОТ
REORGANIZED HONOUR GUARD COMPANY



БНМАУ-ын Ардын цэргийн жанжны 1956 оны 53 дугаар тушаалаар томилсон хүндэт харуулын тусгай ротын дарга, ахлах дэслэгч Төмөрийн Туваанжав

First Lieutenant Tuvaanjav Tumur, appointed by order #55 of the Commander-in-Chief of the PRM on 1956, Commander of the Honor Guard Company

## ШИНЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН БИЕИЙН ТАМИР-СПОРТЫН ТУСГАЙ РОТ
REORGANIZED PHYSICAL TRAINING COMPANY



УБХЯ-ны сайдын 1955 оны 71 дүгээр тушаалаар томилогдсон Ерөнхий штабын байлдааны бэлтгэл хэсгийн туслах, ерөнхий тренер, хошууч Лэгшидийн Чимэддорж

Major Chimeddorj Legshid, appointed by order #71 of the Commander-in-Chief of the PRM on 1955, the assistant and general trainer of combat preparedness of the General Staff



“Алдар” нийгэмлэгийн анхдагчид. Зүүн гар талаас Л.Моломжамц, Азийн аварга Агваан, ОУХМ Данзан, хурандаа Б.Тавхай, Цэнд, МУГТ Зундуй, СМ Чагцал

First pioneers of the “Aldar” association. From the left side, L.Molomjamts, Asian Champion Agvaan, Danzan, Colonel B.Tavkhai, Tsend, Zundui, and Chagtsal



Найрамдалт армиудын спорт хороо (СКДА)-ны анхдугаар хуралд БНМАУ-ын Цэргийн ба НАХХЭЯ-ны орлогч сайд хошууч генерал Б.Цог оролцож, гарын үсэг зурснаар Алдар нийгэмлэг нь тус спорт хорооны ууган гишүүн болсон. 1957 он

Major General B.Tsog, Deputy Minister of Military and SSA, attended the first meeting of the Sport Committee for Friendship Army (SCFA) and signed for joining this committee. Aldar association was frist member of the Commitee. 1957



“Алдар” нийгэмлэгийн зуны цэнгэлдэх хүрээлэнгийн нээлт. 1957 он
Opening of Summer Stadium for “Aldar” Association. 1957

# МОНГОЛ АРДЫН ЦЭРЭГ ЭНХ ЦАГИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД
## PARTICIPATION OF THE MONGOLIAN PEOPLE'S MILITARY FORCES IN PEACE TIME CONSTRUCTION



Д.Сүхбаатар, Х.Чойбалсангийн бунхант индэр
Mausoleum of D.Sukhbaaatar and Kh.Choibalsan



Нэгдүгээр 40 мянгат
The First 40 myangat



Одоогийн Хөдөө аж ахуйн их сургууль
The present University of Agriculture



Сүүн заводын барилга
The building of Milk factory



Монгол ардын цэрэг улс ардын аж ахуйг хөгжүүлэх 2 дугаар таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд амжилттай оролцов.

Mongolian People's Military Forces successfully participated in the implementation of 2nd five-year plan for economic development.

150 ~~831~~

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН ТӨВ ХОРООНЫ УЛС ТӨРИЙН ТОВЧООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

1954 оны 7 дугаар сарын 7[illegible]-ны өдөр

№ 33/194

Улаанбаатар хот

С/ХБААТАР-ЧОЙБАЛСАНГИЙН БУНХНЫ БАРИЛГЫГ БАРЬЖ ДУУССАН ТУХАЙ

С/хбаатар-Чойбалсангийн бунхны барилгыг эрхэлсэн Засгийн Газрын Комиссын мэдэгдлийг сонсоод, М А Х Намын Төв Хорооны Улс Төрийн товчоонсоо ТЭМДЭГЛЭХ НЬ:

С/хбаатар-Чойбалсангийн бунхны барилгыг 1953 оны 7-р сарын 15-аас барьж эхлээд 1954 оны 7-р сарын 5-нд хугацаанаас нь өмнө дуусгажээ.

Барилгын нийт ажил, Улсыг Батлан Хамгаалах яамны х/ч-ээр г/йцэтгэгдсэн бөгөөд өнгөлөх ажлыг Зөвлөлт Холбоот Улсаас уригдаж ирсэн гантигч-мастерууд г/йцэтгэжээ.

Хайрт эх орныхоо төлөө манай ард т/ний баяр бахдалыг төр//лсөн, манай /еийн нэр төртэй дурсгалыг б/тээхээр барилгачид болон ялангуяа Зөвлөлтийн мэргэжилтэн нар б/х х/чадлаа гаргаж хөдөлмөрийн их эрчилттэй ажилласны /рээр бунхны барилга сайн чанартай бөгөөд хугацаанаас өмнө баригджээ.

151 ~~832~~

151 ~~832~~

-2-

М А Х Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооноос ТОГТООХ НЬ:

1. Бунхны барилга сайн чанартай баригдсан гэж /зс/гэй

2. Барилт өнгөлөлтийн талаар б/рэн дууссан дурсгалын том барилга болох С/хбаатар-Чойбалсангийн бунхныг х/лээн авч нээс/гэй

3. Бунхны барилтыг барихад техникийн болоод бусад их тусламж /э//лсэн явдалд Зөвлөлт Засгийн Газарт г/н талархлыг илэрхийлс/гэй.

4. Зөвлөлтийн мэргэжилтэн нар болон бунхан барихад шалгарсан барилгачдыг шагнах сайшаахыг Б Н М А Улсын Сайд нарын Зөвлөлд даалгасугай.

5. С/хбаатар-Чойбалсангийн бунхны барилтыг Б Н М А Улсын Сайд нарын Зөвлөлийн хэрэг эрхлэх газрын даргад шилж//лэн өгс/гэй.

УЛС ТӨРИЙН ТОВЧООНЫ ГИШҮҮД

(Ю. ЦЭДЭНБАЛ)
(Д. ДАМБА)
(Б. ЖАМБАЛДОРЖ)
(Б. ШИРЭНДЭВ)
(Ц. ДҮГЭРСҮРЭН)

ОРЛОГЧ ГИШҮҮД

(И. ЛХАМСҮРЭН)
(Д. ЦЭДЭВ)

МУҮТА, УТНОНББА, Х-4, Д-21, ХН-17, Х-151-152






504

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

74

ТОГТООЛ

1958 оны 12 дугаар сарын 16 ны өдөр

Дугаар 394

Улаанбаатар хот

Сүүний заводыг хүлээж авахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай.

Б Н М А Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Сүүний заводыг 1958 онд хүлээж авах болсонтой холбогдуулан, 1959 онд олгох гүйлгээ хөрөнгөнөөс 100 000 төгрөгийг сүүний заводад урьдчилан олгохыг Сангийн Яам/н.ДҮГЭРСҮРЭН/-д зөвшөөрсүгэй.

2. Ойрын хугацаанд зарим үйлдвэрийн газруудыг ашиглалтад хүлээн авах явдалтай холбогдсон зардлыг тус тусын төсвийн хэмнэгдлээс хэвэрлэлтын өсөөр гаргахыг Аж Үйлдвэрийн Яам /н.НАЙДАНСҮРЭН/-д зөвшөөрсүгэй.

3. Сүүний заводыг ашиглалтад оруулахад хэрэгдэгдэх материалыг яаралтай авахуулахаар сүүний заводын механик н.[illegible]-г Зөвлөлт Улсад энэ оны 12 дугаар сарын 18-ны дотор явуулахыг Аж Үйлдвэрийн Яам/н.НАЙДАНСҮРЭН/-д даалгасугай.

4. Материал худалдан авахад 6 000 төгрөгийг зохих валютаар нь гүйцээлгэхийг Сангийн Яам/н.ДҮГЭРСҮРЭН/, Улсын Банк/н.[illegible]/ нарт даалгасугай.

5. Сүүний заводыг ажиллуулахад зориулан, сүү 15 тонныг энэ оны 12 дугаар сарын 24-ний дотор нийлүүлэх ба цаашид 1959 оны 4 дугаар сарын 1 хүртэл хоногт 1,5 тонн сүүг тогтмол нийлүүлж байхыг Хөдөө Аж Ахуйн Яам/н.[illegible]/-д үүрэг болгосугай.

6. Сүүний заводын хэрэгцээнд "Социализмын зам", "Замт", "Чойбалсангийн зам" нэгдлүүдээс сүүг бэлтгэлийн үнээр олгох, 1959 онд улсад тушаах сүүнд нь оруулан тооцохыг Төв [illegible]

505

-2-

75

гүйцэтгэх захиргаа/н.[illegible]/-т даалгасугай.

7. Сүүний заводыг усаар хангахын тулд усны шинжилгээг 1959 оны 1 дүгээр сард багтаан хийж, зохих дүгнэлтийг Аж Үйлдвэрийн Яамнд гаргаж өгөхийг Геологи ба Уулын Үйлдвэрийн Яам /н.[illegible]/-т даалгасугай.

Б. Н. М. А. Улсын Сайд нарын Зөвлөлийн дарга — ЦЭДЭНБАЛ

Б. Н. М. А. Улсын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг Эрхлэх Газрын 1 дүгээр орлогч дарга — ЦЭРЭНШАВ

Дууйбар үнэн: Тогтоол [illegible] эрхлэгч /[illegible]/



Ардын хувьсгалын 35 жилийн ойн ёслолын жагсаал.

Military Parade for the 35th Anniversary of the People's Revolution.

Б. Н. М. А. У.

ЦЭРГИЙН БА НИЙГМИЙГ АЮУЛААС ХАМГААЛАХ ХЭРГИЙГ ЭРХЛЭХ ЯАМНЫ ЦЭРГИЙН ХЭРГИЙГ ЭРХЭЛСЭН ОРЛОГЧ САЙД БӨГӨӨД АРДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧИЙН ТУШААЛ

1995 6 оны 5 дугаар сарын 31 №202 Улаанбаатар хот

Утга нь: Парадын бэлтгэлийг хангах тухай.

Ардын хувьсгалын 35 жилийн ойгоор явуулах цэргийн парадын бэлтгэлийг хангахын тулд ТУШААХ НЬ:

1.Улаанбаатар,Сонгино гарнизоны цэргийн анги,салбаруудын нийт бүрэлдэхүүнийг парадад бүрэн оролцуулсугай. Харуул манаатай ба өвчтэй хүмүүсээс бусдыг парадад дүүрэн оролцуулахыг анги,салбаруудын дарга нарт үүрэг болгосугай.

2.Парадын бэлтгэлийг 7 хоногт өглөөний цагаар 4 удаа,оройн цагаар 2 удаа тус бүр 2 цагийн багтаамжтайгаар явуулж байхыг анги, салбаруудын дарга нарт даалгасугай.

Парадад жагсах анги,салбаруудын офицеруудаас бусад бүрэлдэхүүнийг төмөр малгайтай,офицеруудыг зуны малгайтайгаар жагсаасугай.

3.Анги,салбарууд дээр явагдах парадын бэлтгэлийг шалган туслахыг байлдааны бэлтгэлийн даргад даалгасугай.

Нэгдсэн парадын бэлтгэлийг шалгаж над илтгэхийг ардын цэргийн штабын даргад үүрэг болгосугай.

4.Парадад жагсах анги,салбаруудыг зэвсэг хэрэглэлээр хангахыг артиллерийн бэлтгэлийн даргад даалгасугай.

5.Танкийн ротын танкийн аккумуляторыг засварлаж цэнэглэж 6-р сарын 15-д бэлхэн болгож өхийг авто тээврийн тасгийн даргад даалгасугай.

6.Парадад явган жагсах ангиудын нэгдсэн бэлтгэлийг 6-р сарын 18.25-д тусгай батальоны өвлийн байранд байлдааны бэлтгэлийн тасгийн даргаас удирдаж явуулсугай. Танкийн ба мотомеханикжуулсан ангийн нэгдсэн бэлтгэлийг 6-р сарын 21.30-д Хужирбулангийн районд тээврийн тасгийн даргаас удирдаж явуулсугай.

Парадад жагсах нийт ангиудын нэгдсэн бэлтгэлийг 7-р сарын 2 ба 9-ний өдрийн өглөө төв талбайд тус тус явуулсугай.

Ц. ба Н. А. Х. Х. Э. Яамны Цэргийн хэргийг эрхэлсэн
орлогч сайд бөгөөд ардын цэргийн
командлагч ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ /ЛХАГВАСҮРЭН/

. . . хувь цэхисон . . . . . . . . .
нийлсэн . . . . . . . . . .


B45-26



Дайчид галын бэлтгэлийн хичээл дээр.
Soldiers at the training for firing.